



МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 4 сарын 28 өдөр

№ 23/61

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 23/10 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн гаргасан 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА,



★★



МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

20 23 оны 4 сарын 28 өдөр

№ 23/02

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалт, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа” гэж 4.1.7 дахь заалтаар нэмж оруулсугай.
2. Энэ тогтоолын 1-т зааснаар шийдвэрлэсэнтэй холбоотой Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, улсын бүртгэлд бүртгүүлэх болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д олгосугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Ч.Хашчулуун)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА,



★★



МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 4 сарын 28 өдөр

№ 28/03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.12 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 2 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2023 оны 5 дугаар 01-ний өдрөөс 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх цалингийн зардлын төсвийг энэ тогтоолын Хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолын Хавсралтаар батлагдсан зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч (Ч.Хашчулуун)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА,


116216030...5221078
УЛААНБААТАР ХОТ

Ч.ХАШЧУЛУУН



★★



**"МИК ХОЛДИНГ" ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН
ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ**

Зардлын төрөл	Сарын цалин		Давтамж	Хүний тоо	Нийт			Үүнээс:			
	суурь	нэмэгдэл			суурь	нэмэгдэл	нийт	2023/05/01-2023/12/31		2024/01/01-2024/04/30	
								суурь	нэмэгдэл	суурь	нэмэгдэл
Цалин	700,000	500,000	12	9	75,600,000	54,000,000	129,600,000	50,400,000	36,000,000	25,200,000	18,000,000
ТУЗ-ийн гишүүн	700,000	500,000	12	9	75,600,000	54,000,000	129,600,000	50,400,000	36,000,000	25,200,000	18,000,000
НДШ ¹	86,100	61,500	12	9	9,298,800	6,642,000	15,940,800	6,199,200	4,428,000	3,099,600	2,214,000
Нийт зардал	786,100	561,500	12	9	84,898,800	60,642,000	145,540,800	56,599,200	40,428,000	28,299,600	20,214,000

¹ нийгмийн даатгалын шимтгэл